# МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН АНХААРАЛД

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн тайлан хүлээж авах, боловсруулах, бүртгэх цахим систем ашиглалтад орлоо. Иймд та бүхэн доорх вэбсайтаар дамжин нэвтэрч хуулийн этгээдийн бол гүйцэтгэх удирдлага, иргэн бол өөрийн нэг удаагийн кодоор эсвэл банкны эрхээр **и–монголиа** системээр дамжин нэвтрээрэй.



**WWW.MLA.FRC.MN/SIGNIN**







Системд нэвтрэхтэй холбоотой асуудлаар: **(51)–261101**
Программ холбох, мэдээлэл бүртгэхтэй холбоотой асуудлаар: **94228477**

2024 ОНЫ 12-Р САРЫН 20-НЫ ӨДӨР
ХУВИЛБАР 1.0.1

# МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ТАЙЛАН ХҮЛЭЭЖ АВАХ, БОЛОВСРУУЛАХ, БҮРТГЭХ ЦАХИМ СИСТЕМ

## ГАРЫН АВЛАГА
## ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ БОЛОН БАРЬЦАА ХӨРӨНГӨ БҮРТГЭХ

### 1. ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ ҮҮСГЭХ

"*Зээлийн бүртгэл – Зээлийн гэрээ*" цэс рүү орж [**НЭМЭХ**] товч дарж, нээгдэх дэлгэцийг дараах байдлаар бөглөнө.

*Зураг 1.1 Зээлийн жагсаалт*




| № | Зээлийн гэрээний № | Овог / Нэр | Утасны дугаар | Батлан даагчтай | Барьцаа хөрөнгө | Олгосон огноо | Олгосон дүн | Хүү/Сараар | Хугацаа/Хоногоор | Зээлийн төлөв |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | ЗГ1111 | Г.Энх-Амгалан | 80254324 | Үгүй | Тийм | 2024-12-01 | 300,000.00 | 1.00 | 31 | Хэвийн |
| 2 | ЗГ1212 | Интеллижент финанс | | Үгүй | Үгүй | 2024-11-05 | 500,000.00 | 3.00 | 50 | Хэвийн |
| 3 | 111111 | Ц.Булган | | Үгүй | Тийм | 2024-02-08 | 500,000.00 | 4.00 | 70 | Хугацаа хэтэрсэн |
| 4 | 111112 | Интеллижент финанс | | Үгүй | Үгүй | 2024-12-04 | 500,000.00 | 4.00 | 7 | Хугацаа хэтэрсэн |
| 5 | 9010102 | Г.ИТГЭЛ | 99647551 | Үгүй | Тийм | 2024-12-04 | 100,000.00 | 3.00 | 35 | Хаагдсан |
| 6 | 9010103 | Г.ИТГЭЛ | 99647551 | Үгүй | Тийм | 2024-12-04 | 4,513,399.06 | 3.00 | 35 | Хэвийн |
| 7 | Зээлийн гэрээний дугаар-2 | Г.ИТГЭЛ | 99647551 | Үгүй | Тийм | 2024-12-04 | 100,000.00 | 3.00 | 35 | Хэвийн |
| 8 | 9010101 | Г.ИТГЭЛ | 99647551 | Үгүй | Тийм | 2024-12-04 | 123,123.00 | 3.00 | 35 | Хэвийн |
| 9 | ЗГ003 | Г.Энх-Амгалан | 80254324 | Үгүй | Үгүй | 2024-12-10 | 100,000.00 | 1.00 | 35 | Хэвийн |

*Зураг 1.2 Зээл бүртгэлийн дэлгэц*




* тэмдэгтэй талбаруудыг заавал бөглөх шаардлагатай.

<u>Зээлдэгчийн мэдээлэл</u>

- **Хувь хүн байгууллага эсэх** – Хувь хүн, Байгууллага сонголтоос сонгоно.
- **Регистрийн дугаар** – Зээлдэгчийн РД оруулж **” →” эсвэл ENTER** товч дарахад Зээлдэгчийн Овог болон Нэр автомат бөглөгдөнө.
- **Хаяг** – Талбарыг дарахад дараах дэлгэц гарч ирэх ба холбогдох талбаруудыг бөглөсний дараа **ХАДГАЛАХ** товч дарна. *МАР дээр байршил заавал сонгож өгөх шаардлагагүй.*

*Зураг 1.3 Зээлдэгчийн хаяг оруулах дэлгэц*



Олгосон зээлийн мэдээлэл

- **Гэрээний дугаар** – Зээлийн гэрээний дугаар оруулна.
- **Зээл олгосон огноо** – Зээл олгосон огноог YYYY-MM-DD форматаар бичих эсвэл календараас сонгох боломжтой
- **Гэрээний хугацаа /Хоногоор/** - Зээлийн гэрээний хугацааг хоногоор оруулж өгнө.
- **Дуусах огноо** – Бөглөхгүй, Программ автомат тооцоологдоно.
- **Олгосон зээлийн дүн** – Зээлийн хэмжээг оруулна.
- **Зээлийн хүү (сараар)** – Зээлийн сарын хүүг оруулж өгнө. Таслаалс хойш 2 оронтой байна.
- **Зээлийн үлдэгдэл** – Бөглөхгүй, Программ зээлийн төлөлт бүртгэхэд авто тооцооллоно.
- **Батлан даалттай эсэх** – Хамтран зээлдэгчтэй үед чеклэж, Батлан зээлдэгчийн РД, Овог, Нэр болон утасны дугаар бөглөнө.
- **Барьцаа хөрөнгөтэй эсэх** – Бөглөхгүй, Зээлтэй холбоотой барьцаа хөрөнгийн мэдээлэл бүртгэх үед программ авто чеклэнэ.
- **Мэдэгдэх хуудас илгээсэн огноо** – Бөглөхгүй, **[Мэдэгдэх хуудас илгээх]** товч дарахад бөглөсөн утгыг харуулна.
- **Мэдэгдэх хуудас илгээсэн суваг** – Бөглөхгүй, **[Мэдэгдэх хуудас илгээх]** товч дарахад бөглөсөн утгыг харуулна.

Зээлийн мэдээлэл үнэн зөв бөглөснийг шалгасны дараа [**ХАДГАЛАХ**] товч дарснаар системд зээлийн бүртгэл нийлүүлэгдэнэ.

Талбар хооронд шилжихдээ keyboard-ны TAB товч ашиглах боломжтой.

## 2. БАРЬЦАА ХӨРӨНГӨ БҮРТГЭХ

Зээлийн мэдээлэл бүртгэж хадгалсны дараа [**Барьцаа хөрөнгө бүртгэх**] товч дарж, барьцаатай холбоотой талбаруудыг дараах байдлаар бөглөнө.

*Зураг 2.1 Барьцаа хөрөнгө бүртгэх дэлгэц*



* тэмдэгтэй талбаруудыг заавал бөглөх шаардлагатай.

Барьцаа хөрөнгийн мэдээлэл

- **Барьцаа хөрөнгийн төрөл** – Үндсэн 10н хөрөнгийн төрлөөс холбогдох барьцааны төрлийг сонгож өгнө.
  Барьцаа хөрөнгийн төрөл зүйлээс хамаарч бөглөх талбарууд өөр өөр байна.
- **Төрөл зүйл** – Сонгосон барьцаа хөрөнгийн төрөлтэй хамааралтай төрөл зүйлсийн жагсаалт гарч ирнэ. Жишээ нь: Цахилгаан хэрэгсэл хөрөнгийн төрөл сонгоход Төрөл зүйл дээр угаалгын машин, зурагт, хөргөгч гэх мэт сонголтууд гарч ирнэ.
- **Үнэлгээ** – Тухайн барьцаа хөрөнгийн үнэлгээний дээд хэмжээг оруулна.
- **Барьцаалсан үнэлгээ** – Тухайн барьцаа хөрөнгийг хэдээр үнэлж, зээл олгосон дүнг оруулна. Барьцаа хөрөнгүүдийн барьцаалсан үнэлгээний нийлбэр нь Зээл олгосон дүнтэй тэнцүү байна.
- **+Барьцаа хөрөнгийн зураг** – 5mb бага хэмжээтэй хэдэн ч зураг оруулах боломжтой.

Барьцаа хөрөнгө нэмэх товчийг дарж 1 зээл дээр олон барьцаа хөрөнгө бүртгэх боломжтой.